

11-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Анги бүлэг ...
Хугацаа: 60 минут

Сурагчийн нэр

“А” ХУВИЛБАР

- 1 Тэгш бус байдлыг илэрхийлэх хамгийн түгээмэл ойлголт аль вэ?
А. Давхраажилт В. Нэр хүнд С. Боловсрол D. Эд хөрөнгө

1 оноо
- 2 Түүх ,соёл, урлаг, амьдралын хэв маяг, үнэт зүйл, үнэлэмж, уламжлал зэрэг соёл хоорондын харилцааны олон хэлбэрийг багтаасан өөр соёлын орчинтой биечлэн танилцахыг..... гэнэ.
А. Соёлын үйлдвэрлэл В. Үндэсний соёл
С. соёлын аялал жуулчлал D. соёлын үйлчилгээ

2 оноо
- 3 Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоорой. Үнэт цаасны худалдаачинг гэнэ.
А. Брокер В. Эдийн засагч С. Бизнесмен D. Бизнес эрхлэгч

2 оноо
- 4 Иргэний нийгэм хэмээх ойлголтын “иргэний” гэсэн үг нь ямар үгнээс үүсэлтэй вэ ?
А. Соёлтой В. Бүдүүлэг, зэрлэг С. Ёс суртахуунлаг D. Өндөр, боловсронгуй

1 оноо
- 5 ”Нийгмийн гишүүн бүрийн амь бие, эд хөрөнгийг нийтийн хүчээр сахин хамгаалах чадвартай нийгмийн холбооны хэлбэрийг олон хэрэгтэй бөгөөд гишүүн бүр энэ нэгдэлд нэгдэх ёстой. Ингэснээр гагцхүү өөрөө өөрийгөө захирч урьдын адил бусдаас хамааралгүй эрх чөлөөтэй үлдэнэ” гэж хэн хэлсэн бэ?
А. Жан Локк В. Жан Жак Руссо С. Ф.Бастиа D. Т.Гобсс

2 оноо
- 6 Монгол улсын шинэ Эрүүгийн хууль хэдэн онд батлагдсан бэ?
А. 2001 В. 2002 С . 2013 D . 2015

2 оноо
- 7 Олон улсын харилцааны “Хөрш орнууд” гэсэн ойлголт нь юуг гол хэмжүүр болгон авч үздэг вэ?
А.Газар зүйн байршил В. Эдийн засгийн түвшин
С. Хамтран ажиллах боломж D. Соёлын хөгжил

1 оноо
- 8 Албадлага , урамшууллаар бус харин бусад улсын сэтгэлийг өөртөө татах замаар өөрийн хүсэж буй үр дүнд хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадварыг юу гэж нэрлэдэг вэ?
А. Зөөлөн хүч В. Хатуу хүч С. ухаалаг хүч D. Татах

2 оноо
- 9 Нийгмийн гишүүдийг эрүүл мэндийн үйлчилгээ авах үйлээр нь :
1дэх ангид эдийн засаг, санхүүгийн хувьд амжилттай байгаа, 2 дахь ангид цалингаараа амьдардаг дундаж хэсгийнхнийг, 3дахь ангид ур чадвараараа бага, даржин амьдралтай хэмээн хуваан судалсан судлаач хэн бэ?
А. Ө.Күүс В .Д.Датон С .Гилберт D. Калл

2 оноо
- 10

Соёл өөрийн үнэт зүйлсээ хамгаалж , оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадварыг юу гэдэг вэ?

- A. Соёлын даяаршил B. Соёлын аялал жуулчлал
C. соёлын дархлаа D. Соёлын адилсал

2 оноо

11 Компани бусдаас нэмэлт мөнгө олж авахын тулд бонд буюу өрийн бичгийг гаргаж болно. Мөнгө босгох энэ аргыг хэрэглэх эрхтэй субъектэд хамааралгүйг олно уу?

- A. Орон нутгийн засаг захиргаа B. Банк C. Засгийн газар D. Хувь хүн

2 оноо

12 Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан бүх төрлийн хувьцаа болон бонд, түүнийг худалдах, худалдан авах эрхийн бичгийг гэж нэрлэдэг.

- A. Үнэт цаас B. Хувьцаа C. Бонд D.Облигаци

2 оноо

13 “Хүмүүс бодсон санаснаа чөлөөтэй илэрхийлэх, хүмүүс айдасгүйгээр эвлэлдэн нэгдэх эрхтэй” хэмээсэн нь ардчилалын аль үнэт зүйлст илүү хамаарах вэ ?

- A. Эрх чөлөө B. Авилгын хяналт C. Хариуцлага, гүйцэтгэл D. Өрсөлдөөн

1 оноо

14 Улс төрийн системийн загварыг боловсруулсан судлаач хэн бэ?

- A. Д. Истон B. Г. Алмонд C. Аристотель D. Макиавелли

2 оноо

15 Эд юмсыг бусдад худалдах, өвлүүлэх, шилжүүлэх зэргээр өөрийн эрхийн хүрээнд бүрэн өмчлөх байдал нь ямар эрх вэ?

- A. Эзэмших эрх B. Ашиглах эрх C. Захиран зарцуулах эрх D. Хамгаах эрх

1 оноо

16 Монгол улсын шүүхийн тогтолцооны зөв бүтцийг тэмдэглэнэ үү.

- A. Улсын дээд , аймаг нийслэлийн , сумын, сум дундын, дүүргийн шүүх
B. Улсын дээд, хотын, нийслэлийн, багын, хорооны, дүүргийн шүүх
C. Монголын, аймгийн, баруун, зүүн төвийн бүсийн, говийн шүүх
C. Улс төрийн, шашны, олон нийтийн байгууллагын, захиргааны шүүх

3 оноо

17 НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд тэдгээрийн нэршлийг зөв харгалзуулна уу?

1. ЮНЕСКО A. НҮБ-ын хүүхдийн сан
2. ЮНИСЕФ B. НҮБ-ын хүн амын сан
3. UNIFA C. НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага
A. 1A2C3B B. 1B2A3C C. 1C2A3B D. 1C2B3A

4 оноо

18 Улс төрийн гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлэх хэлбэрүүдээс илүүц дурдсаныг тэмдэглэнэ үү.

- A. Улс орнуудын хооронд гэрээ хэлэлцээр байгуулах
B. Хилийн албадын хамтарсан уулзалт, хурал зохион байгуулах
C. Төрийн тэргүүний айлчлал
D. Хил орчмын иргэдийн амьдралын чанарыг сайжруулах

2 оноо

19 Гажуудлын төрөлд үл хамаарах жишээ аль нь вэ?

- A. Тамхи татах нь тухайн хүний зуршил боловч нөгөө талаас нийгмийн гажуудлын илрэл
B. Олон нийтийн газарт хутга мэс, галт зэвсэг гарган бусдыг айлгах, сүрдүүлэх
C. Хэсэг бүлгээрээ нийлэн мөрийтэй болон бооцоотой тоглоом тоглох

20

D.Шивээс хийлгэж, чих уруулаа цоолох, этгээд чимэг зүүлт зүүх

2 оноо

Монгол улсад амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлыг анх удаа судалж үзэх 2016 оны хооронд 10-25 насны 605 хүн амиа хорлосон ба энэ нь нийт 2055 тохиолдлын 29.44 хувийг эзэлж байна. Мөн энэ хугацаанд 10-14 насны хүүхэд амиа хорлосон 78 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод хамгийн олон буюу 27 (34.6 хувь), орон нутгаас Хөвсгөл аймагт хамгийн олон буюу 10.2 хувь нь бүртгэгджээ. Амиа хорлох үзэгдлийг нийгмийн орчин, нийгмийн бүтэц, нийгмийн нөхцөлтэй нь тухайлбал гэр бүл, шашин, үндэстэн улс төрийн амьдрал, мэргэжлийн бүлэг зэрэгтэй холбож үзсэн эрдэмтэн аль нь вэ?

A.З.Фрейд В.Э.Дюркгейм С.Шелдон D.Ч.Ломброзо

3 оноо

21

Соёлын эрх чөлөөний суурь зарчимд хамааралгүй өгөдөл оруулсан бол аль вэ?

- A. Нийгмийн амьдрал дахь оролцоог хязгаарлах
- B. Амьдралын хэв маягийг үгүйсгэх
- C. Иргэдийн соёлыг оролцуулан бүх соёлыг ижил тэгш үнэлж, хүндэтгэх
- D. Нийгмийн бусад гишүүдийн адилаар амьдрахыг шаардлага болгох

2 оноо

22

Манай эрин үеийн эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн шалгуур, улс үндэстэн, гэр бүл, хувь хүний эрхэмлэх зүйл бол эх дэлхийн зүй тогтолд хүндэтгэлтэй хандах, байгалиа нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийг хамгаалах явдал юм гэж ямар баримт бичигт тодорхойлсон бэ?

- A. “Соёлын төрөл зүйл, соёл хоорондын харилцааг тэтгэхүй” илтгэл
- B. “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөр 2015 он
- C. “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого” 2012 он
- D. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” 2005 он

2 оноо

23

Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг төрийнгэнэ.

A. Мөнгөний бодлого B. Сангийн бодлого C. Зээлийн бодлого D. Хүүгийн бодлого

2 оноо

24

Дотоодын нийт бүтээгдэхүүнд оруулж тооцохгүй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний жишээ аль нь вэ?

- A. Талхны үйлдвэрийн худалдан авсан гурилын өртөг
- B. Тухайн жилд үйлдвэрлэсэн талхны үнэ
- C. Бат машин засварын газар байгуулж, төлбөртэй засвар хийж мөнгө олдог.
- D. Болд 1 га газар хүнсний ногоо тарьж, ургацаа худалдан борлуулж, татвар төлсөн

1 оноо

25

2012 онд УИХ-ын 76 гишүүний 48 нь харьцангуй олонхийн саналаар сонгогдож, 28 нь намуудын сонгогчдоос авсан саналын хувьд тэнцүүлэн сонгогдсон. 2012 оны УИХ-н сонгуулийг сонгуулийн ямар системээр зохион байгуулсан бэ?

- A. Мажоритари систем B. Пропорциональ систем
- C. Харьцангуй олонхын систем D. Холимог систем

2 оноо

26

“Улс төр бол эрх мэдэлд оролцох түүнийг хуваарилахын төлөө эрмэлзэн тэмцэх явдал болно” гэж хэн тодорхойлсон бэ?

A. К.Маркс B. Д. Истон C. Аристотель D. Г. Лассуэл

2 оноо

27

Иргэн С 2017 онд хувийн хувийн 2 өрөө орон сууц 70 сая төг-өөр худалдан борлуулжээ. Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогоосоо хэдэн хувийг татварт төлөх вэ?

A. 5% B. 2% C. 10% D. 12%

2 оноо

28

Шүүх нь аливаа хэрэг маргааныг шийдвэрлэх хууль ёсны эрх мэдэлтэй, бие даасан хараат бус байх шаардлагатай байдаг нь шүүхийн ямар байх баталгаа болдог вэ?

- A. Тэнцвэртэй байх B. Тэгш байх C. Шударга байх D. Ил тод байх

2 оноо

29

Монгол улс гуравдагч хөрштэйгээ хэзээнээс дипломат харилцаа тогтоож ирснийг зөв холбоно уу?

1. Монгол улс ба АНУ-ын харилцаа A. 1990 он
2. Монгол улс ба Япон улсын харилцаа B. 1987 он
3. Монгол улс ба БНСУ-ын харилцаа C. 1972

- A. 1B2A3C B. 1C2B3A C. 1C2A3B D. 1B2C3A

4 оноо

30

Гадаад хөрөнгө оруулалтын бодлогод эрх зүйн шударга ёсны тодорхой зарчмууд алдагдсанаас байгаль орчин сүйдэх, хүний эрх зөрчигдөх, тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжихгүй байх зэрэг сөрөг үр дагаврууд гарсаар байна. Энэ нь олон улсын эрх зүйн ямар тулгуур зарчим зөрчигдсөнөөс болсон бэ?

- A. Маргаантай асуудлыг энх тайвнаар зохицуулах
B. Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэх
C. Хүч үл хэрэглэх, хүчээр түрий барьж айлган сүрдүүлэхгүй байх
D. Улс орнууд биенийхээ дотоод хэрэгт үл оролцох

2 оноо

2 ДУГААР ХЭСГИЙН ДААЛГАВАР

31

Дараах өгөдлийг зөв харгалзуулна уу?

- | | |
|-----------------------------|--|
| 1. Төрөлх статус шаардлагыг | A. Хоёр ба түүнээс дээш хоорондоо нийцэхгүй үүргийн эсрэг зайлшгүй биелүүлэх нөхцөл |
| 2. Олдмол статус | B. Нийгмийн байр суурьт байх ёстой буюу зохимжтой гэж үзсэн үйл Үйл байдал |
| 3. Статус | C. Хүний амьдралын тодорхой нэгэн үед шийдвэрлэх үүрэг бүхий нэг Нөгөөгөөсөө илүү чухал байдгийг нийгэмд хүлээн зөвшөөрсөн Нийгмийн байр суурь |
| 4. Мастер статус хандлагын | D. Тухайн нийгмийн тогтолцоонд аливаа хувь хүний эзэлж буй байр Суурь, түүнд хамаарах эрх, үүрэг, бусдын зүгээс хандах Цогц |
| 5. Үүрэг | E. Хүний өөрийнх нь хичээл зүтгэл, чармайлтаар олж авдаг Нийгмийн байр суурь |
| 6. Үүргийн зөрчилдөөн | F. Тодорхой нэг хүний өвөрмөц авъяас чадвар, өөрт нь заяагдмал, Өөрөө сонгох боломжгүй байдаг нийгмийн байр суурь |
- A. 1E2F3C4D5A6B B. 1F2D3E4B5C6A
C. 1A2C3E4F5D6B D. 1F2E3D4C5B6A

6 оноо

32

Доорх соёлын түүхэн хэв маягаас аж ахуй эрхлэлтийг шалгуур болгосон ангилалд багтах төлөөллийг олно уу?

1. Ан агнуур 2. Түүвэрлэгчдийн соёл 3. Нүүдэлчдийн соёл
4. Газар тариалангийн соёл 5. Өрнийн 6. Дорнын

- A. 1,2,3,4 B. 1,3,4,5 C. 1,2,4,6 D. 1,3,4,6

2 оноо

33

Дараах өгөдлийг зөв харгалзуулна уу?

1. Мөнгөний тэлэх бодлого A. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого зарлагыг Өөрчлөх
2. Мөнгөний хумих бодлого B. Эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин байнга өсч, мөнгө Үнэгүйдэх
3. Төрийн мөнгө- C. Эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин буурах

зээлийн бодлого

4. Инфляци D. Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг багасгах
5. Төрийн сангийн бодлого F. Гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг
Нэмэх
6. Дефляци E. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон
Зээлийн хүү нөлөөлөх
- A. 1E2D3F4B5A6C B. 1D2E3F4A5C6B C. 1C2E3D4F5A6B D. 1F2E3D4A5C6B

6 оноо

34

Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна

1. Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт буурсантай холбоотой томоохон уурхай хаагдаж, олон уурхайчид ажлаа алдсан. A. Мөчлөгийн ажилгүйдэл
2. Хүссэн ажлаа хийхийн тулд гадаад хэл суралцахаар ажлаас завсардсан. B. Бүтцийн ажилгүйдэл
3. Барилгын салбарын үйлдвэрлэл өвөл түр хугацаагаар зогсдог тул одоо ажилгүй байгаа. C. Улирлын ажилгүйдэл
4. 1990-ээд онд эдийн засгийн хямрал бий болж, олон тооны хүмүүс ажилгүй болсон. D. Шилжилтийн ажилгүйдэл
- A. 1A2B3C4D B. 1B2D3C4A C. 1B2D3A4C D. 1A2B3D4C

4 оноо

35

Улс төрийн системийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг харгалзах жишээтэй нь зөвөөр тохируулна уу?

1. Оролт A. Засгийн газрын ээлжит хуралдаанаар нийслэл хотын гэр хорооллын айл өрхөд Цахилгааны үнэ тарифын хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гарав
2. Гаралт B. Сонгуулийн хуулийг өөрчлөх асуудлаар иргэний нийгмийн байгууллагууд УИХ-д Шаардлага хүргүүлжээ.
3. Эргэх холбоо түмний C. Иргэдээс гаргасан саналын дагуу парламент шинэ хууль баталсан нь олон Дэмжлэгийг хүлээжээ.
- A. 1C2A3B B. 1A2C3B C. 1B2A3C D. 1B2C3A

3 оноо

36

Сонгууль, сонгуулийн тогтолцоог зөв харгалзуулна уу?

1. Сонгууль A. Намын нэрээр санал хурааж, авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилах Арга
1. Мажоритари B. Сонгууль явуулах, санал авах, дүн гаргах, суудал хуваарилах арга дүрэм, Журмын цогцыг
2. Пропорциональ C. Сонгогчид зөвхөн нэр дэвшсэн хүний л төлөө саналаа өгдөг ба өрсөлдөгчөөсөө Хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцох арга
3. Сонгуулийн тогтолцоо D. Бүх нийтийн, чөлөөтэй, шууд сонгох, саналаа нууцаар гаргах, тэгш эрхээр хангагдах
4. Сонгуулийн Зарчим E. Санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийх түгээмэл арга хэрэгсэл
- A. 1E2C3D4B5A B. 1C2E3D4B5A C. 1E2C3A4B5D
D. 1A2B3D4C5E

4 оноо

37

Хуульчилсан акт тус бүрийг батлан гаргах төрийн албан тушаалтантай нь зөв тохируулна уу?

1. Тогтоол A. Засгийн газрын агентлагийн дарга
2. Зарлиг B. Засгийн газар
3. Тушаал C. Ерөнхийлөгч
- A. 1B2C3A B. 1A2C3B C. 1C2B3A D. 1B2A3C

2 оноо

38

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх хугацааг харгалзуулна уу?

- | | |
|--|-------------|
| 1. Гомдол хүлээн авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж Төлсөн баримт, хэргийн оролцогчдын гомдлыг хавсарган Гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд ...дотор улсын Дээд шүүхэд хүргүүлнэ | A. 90 хоног |
| 2. Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш...дотор хэрэг Үүсэх тухай захирамж гаргана. | B. 14 хоног |
| 3. Хэрэг үүссэн өдрөөс хойш орон нутагт...дотор шүүх нэхэмжлэлийг Хариуцагчид гардуулна | C. 14 хоног |
| 4. Давж заалдах гомдол гаргасан хэргийг, давж заалдах шүүх Хүлээн авснаас хойш ...дотор хянан шийдвэрлэнэ. | D. 3 хоног |
| 5. Зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаа хэтэрсэн Тохиолдолд гомдол хүлээн авсан захиргааны байгууллага, Албан тушаалтан хугацаа хэтэрснээс хойш ...дотор нөхөн сэргээнэ. | E. 7 хоног |
- A. 1E2D3A4C5B B. 1C2D3E4A5B C. 1C2E3D4A5B D. 1D2E3C4A5B

5 оноо

39

Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

- | | |
|--------------------------------------|---|
| 1. Монгол улс ба хоёр талын харилцаа | A. Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа Зүүн хойт Ази, Төв Азий олон талт үйл явц, яриа хэлэлцээр, интеграцид үр ашигтай оролцох явдал |
| 2. Монгол улсын олон талт хамтын | B. Монгол улсаас олон улсын хамтын ажиллагаа нийгэмлэгийн хүрээнд явуулах бодлого, олон талт дипломат ажиллагаа. |
| 3. Монгол ба бүс нутгийн олон талт | C. Гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн харилцаа улсорнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны түвшин байнга өсч, Монгол улсыг дэмжигч, хамтран ажиллагч түншүүдийн тоо улам бүр нэмэгдэж байгаа үйл явц. |
- A. 1C, 2B, 3A B. 1B, 2A, 3C C. 1C, 2A, 3B D. 1A, 2C, 3B

3 оноо

40

Олон улсын харилцааны ойлголтуудыг зөв харгалзуулна уу?

- | | |
|---------------------------|---|
| 1. Хөрш орон | A. Тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр буюу “ бараг хууль ёсны” Гэсэн утгатай |
| 2. Олон улсын Харилцаа | B. Тухайн улс үндэстэнтэй шууд хил залгаа оршдог, тэр улсын гадаад дотоод үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход үлэмж нөлөө үзүүлдэг улс орнууд |
| 3. Де-юре | C. Дэлхий улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад Бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбар |
| 4. Де-Факто хоорондын | D. Олон улсын засгийн газар хоорондын хамгийн түгээмэл, нээлттэй, улс Харилцаа, хамтын ажиллагааны хамгийн олон салбар чиглэлийг хамардаг Байгууллага |
| 5. НҮБ | E. Тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр буюу “ хууль ёсны” гэсэн утгатай. |
- A. 1B2C3E4A5D B. 1C2B3E4A5D C. 1D2E3A4B5C D. 1B2E3A4C5D

5 оноо

11-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Анги бүлэг ...
Хугацаа: 60 минут

Сурагчийн нэр

ХУВИЛБАР Б

1 Нийгмийн давхраажилтын хэв маягуудад аль нь хамааралгүй вэ?
А. Эд баялаг В. Боолчлол С. Язгуур D. Каст **1 оноо**

2 Булаан эзлэх, шашин дэлгэрүүлэх, мэдээллийн хэрэгслийн нөлөө зэрэг олон сувгуудаас соёлын үнэт зүйл нэг бүлгээс нөгөөд , нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явц нь юм
А. Соёлын хуримтлал В. Соёлын түгээмэл шинж
С. Соёлын цочирдол D. соёлын нэвчилт **2 оноо**

3 Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоорой. Тодорхой хэмжээний мөнгийг тогтсон хугацааны дараа зохих хүүтэйгээр эргүүлэн төлөхийг амлаж байгааг баталсан үнэт цаасыг гэнэ.
А. Бонд В. Хувьцаа С. Хадгаламж D. Чек **2 оноо**

4нь төрөөс үл хамаарахөөр хоорондын харилцаа, эрх зүйгээр зохицуулагддаг хувь хүмүүс, анги, бүлэг, институтуудын нийлбэр цогц юм.
А. Нийгэм В. Социалист нийгэм С. Аж үйлдвэржсэн нийгэм D.Иргэний нийгэм **1 оноо**

5 Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн засаглал хуваах онолыг үндэслэгчийг нэрлэнэ үү?
А. Н. Макиавелли В. Ж.Локк С. М.Вебер D. Ш. Монтескье **2 оноо**

6 Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хэдэн онд баталсан бэ?
А. 1957 В. 1954 С . 1946 D . 1948 **2 оноо**

7 Улс төрийн гадаад бодлогын хэрэгжилт нь юм.
А.Гадаад харилцаа В. Дайн тулаан
С. Санхүү мөнгөний урсгал D. Иргэд хоорондын харилцаа **1 оноо**

8 Зөөлөн хүчний бодлоготой утга дүйх жишээг олно уу?
А. Батлан хамгаалах салбарын хүчирхэг бэлэн байдал В. Улс төрийн дэглэм нь дэлхийн нийтийн талархалыг хүлээх явдал юм
С. Санхүү мөнгөний асар их нөөц баялаг D. Байгалийн баялагийн хэмжээ үзүүлэлт **2 3 оноо**

9 “Капитал”, “Коммунист намын тунхаг” бүтээлдээ капиталистууд болон ажилчин ангийн зөрчлийг авч үзээд энэ нь нийгмийн өөрчлөлтийн хөдөлгөгч хүч болдог гэж үзсэн сэтгэгч аль нь вэ?
А. М.Вебер В. К.Маркс С. С.Дюркгейм D.Ж.Г.Мид **2 оноо**

10

Археологи, Архитектур, гар урлал, үндэсний тоглоом, хувцас хунар, кино дүрслэх урлал, зар сурталчилгаа зэрэг нь соёлын аль ойлголтод хамаарах вэ?

- A. Соёлын эрх чөлөө
B. Соёлын даяаршил
C. Соёлн орон зай
D. Соёлын үйлдвэрлэл

2 оноо

11 Үнэт цаасыг худалдах, худалдан авах, бусдад шилжүүлэх зэрэг үнэт цаасны арилжаа явагдаж буй газрыг ... гэнэ.

- A. Хөрөнгийн бирж B. Санхүүгийн зах зээл C. Ногдол ашиг D. Банк

2 оноо

12 Ямар нэг компанийн өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж буйг гэрчилсэн баримтыггэнэ.

- A. Бонд B. Хувьцаа C. Хадгаламж D. Үнэт цаас

2 оноо

13 Улс төрийн эрх, эрх чөлөөнд үл хамаарахыг олоорой.

- A. Үзэл бодлоо илэрхийлэх B. Хэвлэн нийтлэх
C. Өмчийн олон хэвшил D. Эвлэн нэгдэх

1 оноо

14 “Ардчилал нь ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал юм” гэж хэлсэн эрдэмтэн аль нь вэ?

- A. Ж. Локк B. Д. Истон C. Р. Даль D. А. Линкольн

2 оноо

15 Баялагийн үр шимийг хүртэх, баялагийг бүрэн хараа хяналтандаа байлгах, баялагийг худалдах, бэлэглэх, арилжих, зээлэх зэрэг эрх нь эдийн засгийн ямар эрхэд хамаарах вэ?

- A. Ёс суртахууны эрх B. Хүний эрх C. Өмчлөх эрх D. Хөдөлмөрлөх эрх

1 оноо

16 Хяналтын шатны шүүх аль нь вэ?

- A. Улсын дээд шүүх B. Нийслэлийн шүүх
C. Аймгийн шүүх D. Сум, Сум дундын шүүх

3 оноо

17 Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд тэдгээрийн нэршлийг зөв харгалзуулна уу?

4. АСЕАН A. Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга
5. АСЕМ B. Зүүн өмнөд азийн орнуудын холбоо
6. АПЕК C. Ази Европын уулзалт
A. 1A2C3B B. 1B2A3C C. 1B2C3A D. 1C2B3A

4 оноо

18 НҮБ-ын үндсэн зорилтуудыг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

- A. Гадаад худалдааг хөгжүүлэх, ашиг олох
B. Дэлхий дахинд энх тайван аюулгүй байдлыг сахин хамгаалах
C. Үндэстэн улс орнуудын хооронд найрсаг харилцааг хөгжүүлэх
D. Хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх

2 оноо

19 Дараах ойлголтуудаас аль нь бурангуй үзлийг тодорхойлсон байна вэ?

- A. Нэг бүлэг давуу боломж олгосон атлаа нөгөөгийнх нь боломжийг хаах үйлдэл
B. Хүний нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тодорхойлж байдаг.
C. Нэг бүлгийнхэний зүгээс нөгөө бүлгээ тодорхойлдог үзэл бодол хандлага
D. Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдах ойлголт

2 оноо

20 “Зөгий, шоргоолжны эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяагддаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэж өвлөх ёстой үйлдэл хийх чадвар байдгийг соёл гэж тэмдэглэдэг”. Энэ нь хэний үзэл баримтлал вэ?

- A. Э. Кассирер B. А. Гидденс C. Э. Тайлор D. Р. Бенедикт

3 оноо

21 Эдгээрээс аль нь соёлын эрх чөлөөг илэрхийлэх асуудал вэ?

- A. Хэн нэгний эрх чөлөөнд халдах
B. Эрхээ эдлэхгүй байх
C. Амьдрах хэв маягийг тулгахгүй байх

2 оноо

22

D. Өөрийн соёлын орчин тухайн хүний хүссэнээс огт өөр байх сөрөг мэдрэмж

Монгол улсын хэмжээнд 1995оноос өнөөг хүртэл хэрэгжиж буй “ монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр “Мөнх тэнгэрийн бичиг” уран бичлэгийн уралдаан зохиолн байгуулж ирсэн. Энэ нь олон улсын хэмжээн дэх соёлын бодлогын аль чиглэлд хамаарч байна вэ?

- A. Соёлын зорилго, хөгжлийн хандлагыг хүний хөгжилд чиглүүлэх
- B. Соёлын үйл ажиллагаанд хүн бүрийн оролцох бололцоог хангах
- C. Үндэсний хэлний цэвэр ариун байдлыг сахин хамгаалах
- D. Үндэстэн, ястны соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах

2 оноо

23 Нийт эрэлтэд үл хамаарахыг олоорой

- A.Хэрэглээ
- B. Цалин
- C. Дотоод хөрөнгө оруулалт
- D.Төрийн худалдан авалт

2 оноо

24 Тухайн улсын эдийн засгийн чадавхийг харуулдаг үндсэн үзүүлэлтийг тэмдэглэнэ үү?

- A. Нэг хүнд ноогдох ДНБ-ны хэмжээ
- B. Нэрлэсэн ДНБ-ны хэмжээ
- C. Үндэсний цэвэр бүтээгдэхүүний хэмжээ
- D. Бодит ДНБ-ны хэмжээ

1 оноо

25 Сонгуульд өрсөлдөгчөөсөө илүү санал авсан нь ялалт байгуулдаг. Дотроо энгийн олонх, үнэмлэхүй олонх, харьцангуй олонх гэсэн аргатай сонгуулийн тогтолцоо аль нь вэ?

- A.Холимог
- B. Пропорциональ систем
- C. Мажоритар
- D. Уламжлалт

2 оноо

26 “Төр, эдийн засаг, гэр бүлээс ангид орших нийгмийн хүрээг иргэний нийгэм гэнэ” Энэ иргэний нийгмийн тухай тодорхойлсон сэтгэгчдээс хэний үзэл санаа вэ?

- A. К.Поппер
- B. Г.Гегель
- C. Р.Дарендорьф
- D. Р.Путнам

2 оноо

27 Иргэн С 2017 онд хувийн хувийн 2 өрөө орон сууц 70 сая төг-өөр худалдан борлуулжээ. Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогоосоо хэдэн хувийг тагварт төлөх вэ?

- A. 5%
- B. 2%
- C. 10%
- D. 12%

2 оноо

28 Иргэний эрх зүйн харилцаа нь хүний эрх, эрх чөлөөн үндэс болохын хувьд ямар зарчмаар баталгаажсан байдаг вэ?

- A. Чадвар, чадамжийн
- B. Тэгш байдлын
- C. Хүний чөлөөт байдлын
- D. Эрх үүрийн

2 оноо

29 Монгол улсын хувьд ихээхэн ач холбогдолтой олон улсын харилцааны бүс нутгууд болон тэдгээрт харьяалагдах улс орнуудыг зөв харгалзуулаарай.

- 5. Зүүн ба зүүн өмнөд Ази
- 6. Зүүн хойд Ази
- 7. Төв ба Евроази
- A. Тажикстан, Казакстан
- B. БНСУ, Япон
- C. Филиппин, Малайз
- A. 1A2B3C
- B. 1B2A3C
- C. 1C2A3B
- D. 1C2B3A

4 оноо

30 Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны олон тулгуурт бодлогын үндсэн илрэлийг тэмдэглэнэ үү.

- A. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах зорилтуудыг хэрэгжүүлэх
- B. Олон оронтой, цөөн хэлбэрийн харилцаа явуулах
- C. Нөөц бололцоогоо бүрэн дайчлан зохион байгуулах
- D. Олон оронтой, олон хэлбэрийн харилцаа явуулах

2 оноо

2 ДУГААР ХЭСГИЙН ДААЛГАВАР

31 Дараах өгөдлийг зөв харгалзуулна уу?

- 7. Нийгмийн бүлэг
- A. Өөр хоорондын харилцаа холбоо, хамааралд орших статус, үүрэг, хэм хэмжээ, үнэт чанар бүхий хувь хүмүүс, нийгмийн анги

8. Ниймийн институт В. Хувь хүн болон бусад хүмүүсийн хоорондын харилцан үйлдлийг хангах үйл ажиллагаанд оролцох
9. Нийгмийн харилцан хамаарал С. Нийгэмд өрнөж буй бүхий л үйл явцыг бус харин нийгмийн бүтэц, хэм хэмжээ, үйл байдлын өргөн далайцтай суурь өөрчлөлтүүдийг илэрхийлдэг.
10. Нийгмийн оролцоо D. Нөхөн үржихүйн, сурч мэдэх, итгэж бишрэх, дэг журам зэрэг хувь болон хамтын сонирхол, хэрэгцээ үнэлэмжийг хангахад чиглэсэн зохион байгуулалт, ниймийн үйлдлийн хэм хэмжээ, тогтсон хэлбэрүүдийн цогц
11. Нийгмийн бүтэц E. Тодорхой нийтлэг сонирхол, үнэлэмжтэй хүмүүсийн нэгдэл
12. Нийгмийн өөрчлөлт F. Хоёр ба түүнээс олон хувь хүмүүсийн хоорондын харилцаа
- A. 1E2C3F4D5B6A B. 1E2D3F4B5A6C
- C. 1A2E3D4C5B6F D. 1C2F3A4E5D6B

6 оноо

32

Доорх соёлын хэв маягийг түүхэн дарааллаар нь байршуулна уу.

1. Эртний 2. Хүй нэгдлийн 3. Дундад зууны
8. Сэргэн мандалтын 5. Шинэ үеийн 6. Орчин үеийн
- A. 1-3-2-4-6-5 B. 1-3-2-4-5-6 C. 2-1-3-4-5-6 D. 2-1-3-4-6-5

2 оноо

33

Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу?

7. Улсын төсөв A. Төсвийн зарлага нь орлогоосоо давах тохиолдол
8. Төрийн мөнгө зээлийн бодлого B. Татварын хувь хэмжээг багасгах
9. Төсвийн хомсдол C. Төсвийн орлого нь зарлагаасаа давах тохиолдол
10. Төсвийн илүүдэл D. Тухайн улсын жилийн орлого, зарлагын төлөвлөгөө
11. Төсвийн зарлагыг Нэмэгдүүлэх бодлого F. Та өөрийн хөрөнгөөр нийтийн шинжтэй ажил зохион байгуулах
12. Төсвийн орлогыг Бууруулах бодлого E. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний зээлийн хүү нөлөөлөх
- A. 1C2D3E4F5A6B B. 1D2F3A4C5E6B C. 1F2A3C4E5D6B D. 1D2C3A4B5F6E

6 оноо

34

Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна

5. Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт буурсантай холбоотой томоохон уурхай хаагдаж, олон уурхайчид ажлаа алдсан. A. Мөчлөгийн ажилгүйдэл
6. Хүссэн ажлаа хийхийн тулд гадаад хэл суралцахаар ажлаас завсардсан. B. Бүтцийн ажилгүйдэл
7. Барилгын салбарын үйлдвэрлэл өвөл түр хугацаагаар зогсдог тул одоо ажилгүй байгаа. C. Улирлын ажилгүйдэл
8. 1990-ээд онд эдийн засгийн хямрал бий болж, олон тооны хүмүүс ажилгүй болсон. D. Шилжилтийн ажилгүйдэл
- A. 1A2B3C4D B. 1B2D3C4A C. 1B2D3A4C D. 1A2B3D4C

4 оноо

35

Улс төрийн дотоод системийг бүрдүүлж буй үйл ажиллагааг тайлбартай нь зөв харгалзуулна уу?

4. Сонирхлыг илэрхийлэх A. Олон янзын сонирхлыг зохицуулах, чухал шаардлагатайг нь сонгон түүнийг хангах арга замыг тодорхойлон бодлого боловсруулах үйл ажиллагааг хэлнэ
5. Сонирхлыг нэгтгэх B. Сонирхлыг ханган биелүүлэх арга замыг тодорхойлсон бодлогыг нийтээр дагаж мөрдөх шийдвэрт тусгуулж, түүнийг засаглалын эрх мэдлээр биелүүлэх үйл ажиллагааг хэлнэ

6. Сонирхлыг хэрэгжүүлэх
- С. Сонирхлын бүлгүүд өөрсдийн эрх ашиг, сонирхлоо шийдвэр гаргах эрх бүхий байгууллагын анхааралд хүргэхийн тулд төрөл бүрийн арга хэрэгсэл ашиглан явуулж буй үйл ажиллагааг хэлнэ.
- A. 1A2C3B B. 1B2C3A C. 1C2A3B D. 1C2B3A

3 оноо

36 Сонгууль, сонгуулийн тогтолцоог зөв харгалзуулна уу?

2. Сонгууль A. Намын нэрээр санал хурааж, авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилах Арга
3. Мажоритари B. Сонгууль явуулах, санал авах, дүн гаргах, суудал хуваарилах арга дүрэм, Журмын цогцыг
4. Пропорциональ C. Сонгогчид зөвхөн нэр дэвшсэн хүний л төлөө саналаа өгдөг ба өрсөлдөгчөөсөө Хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцох арга
5. Сонгуулийн тогтолцоо D. Бүх нийтийн, чөлөөтэй, шууд сонгох, саналаа нууцаар гаргах, тэгш эрхээр хангагдах
6. Сонгуулийн Зарчим E. Санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийх түгээмэл арга хэрэгсэл
- A. 1E2C3D4B5A B. 1C2E3D4B5A
C. 1E2C3A4B5D D. 1A2B3D4C5E

4 оноо

37

Хуульчилсан акт тус бүрийг батлан гаргах төрийн албан тушаалтантай нь зөв тохируулна уу?

4. Тогтоол A. Засгийн газрын агентлагийн дарга
5. Зарлиг B. Засгийн газар
6. Тушаал C. Ерөнхийлөгч
- A. 1B2C3A B. 1A2C3B C. 1C2B3A D. 1B2A3C

2 оноо

38

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх хугацааг харгалзуулна уу?

6. Гомдол хүлээн авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж Төлсөн баримт, хэргийн оролцогчдын гомдлыг хавсарган Гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд ...дотор улсын Дээд шүүхэд хүргүүлнэ A. 90 хоног
7. Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш...дотор хэрэг Үүсэх тухай захирамж гаргана. B. 14 хоног
8. Хэрэг үүссэн өдрөөс хойш орон нутагт...дотор шүүх нэхэмжлэлийг Хариуцагчид гардуулна C. 14 хоног
9. Давж заалдах гомдол гаргасан хэргийг, давж заалдах шүүх Хүлээн авснаас хойш ...дотор хянан шийдвэрлэнэ. D. 3 хоног
10. Зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаа хэтэрсэн Тохиолдолд гомдол хүлээн авсан захиргааны байгууллага, Албан тушаалтан хугацаа хэтэрснээс хойш ...дотор нөхөн сэргээнэ. E. 7 хоног
- A. 1E2D3A4C5B B. 1C2D3E4A5B C. 1C2E3D4A5B D. 1D2E3C4A5B

5 оноо

39

Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1. Монгол улс ба хоёр талын харилцаа A. Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа Зүүн хойт Ази, Төв Азий олон талт үйл явц, яриа хэлэлцээр, интеграцид үр ашигтай оролцох явдал

2. Монгол улсын олон талт хамтын

В. Монгол улсаас олон улсын хамтын ажиллагаа нийгэмлэгийн хүрээнд явуулах бодлого, олон талт дипломат ажиллагаа.

3. Монгол ба бүс нутгийн олон талт

С. Гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн харилцаа улс орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны түвшин байнга өсч, Монгол улсыг дэмжигч, хамтран ажиллагч түншүүдийн тоо улам бүр нэмэгдэж байгаа үйл явц.

A. 1C, 2B, 3A

B. 1B, 2A, 3C

C. 1C, 2A, 3B

D. 1A, 2C, 3B

3 оноо

40

Олон улсын харилцааны ойлголтуудыг зөв харгалзуулна уу?

6. Хөрш орон

A. Тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр буюу “ бараг хууль ёсны” Гэсэн утгатай

7. Олон улсын Харилцаа

B. Тухайн улс үндэстэнтэй шууд хил залгаа оршдог, тэр улсын гадаад дотоод үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход үлэмж нөлөө үзүүлдэг улс орнууд

8. Де-юре

C. Дэлхий улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад Бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбар

9. Де-Факто хоорондын

D. Олон улсын засгийн газар хоорондын хамгийн түгээмэл, нээлттэй, улс

Харилцаа, хамтын ажиллагааны хамгийн олон салбар чиглэлийг хамардаг Байгууллага

10. НҮБ

E. Тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр буюу “ хууль ёсны” гэсэн

утгатай.

A. 1B2C3E4A5D

B. 1C2B3E4A5D

C. 1D2E3A4B5C

D. 1B2E3A4C5D

5 оноо

АМЖИЛТ ХҮСЬЕ

